



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД НЬ УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ УЯЛДСАН ХЭДИЙ Ч ХЭРЭГЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДТЭЙ НИЙЦСЭН ЭСЭХ, ЧАНАР, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ /2016-2021 ОН/”

АУДИТЫН КОД: ОРА-2022/33-2-ШТА-ГА



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Ц.Нармандах
Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Буян-Ундрах
Утас: 70350757 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Аудитор Б.Бямбатогтох
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/10

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө” /2016-2021 он/ гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга болон Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Мөнхбат, аймгийн Засаг дарга С.Батжаргал нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор /Б.Буян-Ундрах/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	2
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах	БҮЛЭГ 1. 2016-2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдсан байна.	4
Аудитор: Б.Бямбатогтох	1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 92.8 хувь нь “МУТХҮБ-2030” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.	4
2022 оны 10 дугаар сар	1.1.1 “Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 336 ТАХ-ний 91.7 хувь нь дэд бүтцийн салбар руу чиглэсэн байна.	5
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.1.2 “Нийгмийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 108 ТАХ-ний 49.1 хувь нь “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгыг хангахад чиглэсэн байна.	5
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn	1.1.3 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 10.4 хувь нь “Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн байна.	6
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	1.1.4 Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 13.2 хувь нь “Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгыг хангахад чиглэсэн байна.	7
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 94.2 хувь нь “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.	8
	1.2.1 “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгуудад хамаарах 18 зорилтоос 12 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.	9
	1.2.2. “Эдийн засаг”, “Ногоон хөгжил”, “Бүсчилсэн хөгжил” зорилгуудад хамаарах 13 зорилтын 8 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ хэрэгжүүлээгүй байна.	10
	1.2.3. “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийн зорилгод чиглэсэн ТАХ-хэрэгжүүлээгүй, “Сайн засаглал”-ын зорилгуудад хамаарах 6 зорилтын 2 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ хэрэгжүүлээгүй байна.	11
	1.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөөгүйч дунд хугацааны бодлоготой нийцүүлж төлөвлөсөн байна.	12

1.3.1 2016-2020 онд хэрэгжүүлсэн 642 ТАХ-ны 96.3 хувь нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад, 2021 онд хэрэгжүүлсэн 121 ТАХ-ны 94.2 хувь нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн байна.	12
1.3.2 2016-2021 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүдийг орон нутгийн хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөөгүй хэдий ч хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 88.5 хувь нь ОНХИ-тэй нийцсэн байна.	13
1.3.3 Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Аялал жуулчлалын өгөөжтэй-Аз жаргалтай иргэд”, “Аялал жуулчлалын бодлого” зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.	15
1.3.4 2016-2020 оны хооронд Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй байна.	17
БҮЛЭГ.2 Хуулийн шаардлага хангасан ТАХ-г хэрэгжүүлсэн ч хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.	19
2.1 Хөрөнгө оруулалтын 99.4 хувь нь иж бүрэн зөсөлтэй ТАХ хэрэгжсэн байна.	19
2.1.1 Хөрөнгө оруулалтын 99.4 хувь нь иж бүрэн зураг төсөлтэй ТАХ хэрэгжсэн байна.	19
2.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний барилгын чанарт захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.	20
2.2 Төсөл арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнг 2020 оноос тодорхойлж эхэлсэн ч үр дүнг нэгтгэсэн мэдээллийн сан үүсгэж үр нөлөөг үнэлээгүй байна.	22
2.2.1 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг үүсгэж үр нөлөөг үнэлдэггүй байна.	22
2.2.2 Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хүрэх түвшин, үр дүнг 2020 оноос тодорхойлж эхэлсэн байна.	22
2.2.3 Хэнийг ч орхигдуулахгүй байх гэсэн зарчмыг баримтлан хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн байна.	24
2.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	24

	2.3.1 Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.	25
	2.3.2 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан гэх боловч алдаа зөрчил давтан гаргасаар байна.	26
	Аудитын дүгнэлт	27
	Аудитын зөвлөмж	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МУ	Монгол улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУТХҮБ-2030	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХИ	Орон нутгийн хөгжлийн индекс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УДДТ	Ус дулаан дамжуулах төв
УИХ	Улсын Их Хурал
ХБТТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
ХЗА	Хотын захирагчийн алба
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацаатай бодлоготой уялдсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь үр дүн, үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Орхон аймагт 2016-2021 онуудад Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 775 төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, орон нутгийн хөгжлийн индекстэй уялдуулан чанартай, үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, бусад холбогдох баримт материалд үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ-аас хүлээн зөвшөөрсөн төрийн АОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Б.Бямбатогтох нар 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

**Аудитын
явцад учирсан
хүндрэл,
бэрхшээлүүд:**

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ холбогдох мэргэжилтнүүд судалгааг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно.

Ерөнхий мэдээлэл

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан. Тухайн хуулийн 4.1.12¹-т "хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг хэлнэ" гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7² дахь заалтад 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт орсон. Тухайн нэмэлт өөрчлөлтөөр орсон заалтыг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-аас 2020 оны 5 дугаар сард Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталж, ХБТТХ-ыг хүчингүй болгосон байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.2-д “Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.” гэж заасныг үндэслэн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, зорилтууд нь агуулгаараа “Алсын хараа-2050”-д тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-ыг 3 үе шатанд /I үе шат 2021-2030 он, II үе шат 2031-2040 он, III үе шат 2041-2050 он/ хэрэгжүүлэхээр баталсан байна.

¹ хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичгийг.

² төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газарХөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд
хугацааны бодлоготой уялдсан уу?

Бүлэг 1

2016-2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдсан байна.


1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 92.8 хувь нь “МУТХҮБ-2030” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан.

Тухайн бодлогын баримт бичиг нь Эдийн засгийн тогтвортой хөгжил, Нийгмийн тогтвортой хөгжил, Байгаль орчны тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн засаглал гэсэн 4 бүлгийн 32 зарчим, 44 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2016-2020 оны хооронд нийт 57,911.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 642 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

“МУТХҮБ-2030”-ын 4 бүлэгтэй ОНХО-аар 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нийцсэн байдлыг графикаар харуулбал:



Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 52.3 хувь нь эдийн засгийн тогтвортой хөгжлийн бүлэгт, 16.8 хувь нь нийгмийн тогтвортой хөгжлийн бүлэгт, 10.4 хувь нь байгаль орчны тогтвортой хөгжлийн бүлэгт, 13.2 хувь нь “Тогтвортой хөгжлийн

засаглал” бүлэгт хамаарахаар байна. Үлдсэн 7.2 хувь, 46 ТАХ нь “МУТХҮБ-2030”-ын 4 бүлгийн аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

1.1.1 “Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 336 ТАХ-ний 91.7 хувь нь дэд бүтцийн салбар руу чиглэсэн байна.

Орхон аймагт 2016-2020 оны хооронд хэрэгжсэн 642 ТАХ-ээс “МУТХҮБ-2030”-ын “Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн 336 ТАХ хэрэгжсэн байна.

“Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлгийн 6 зорилготой ТАХ-үүд хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Хөдөө аж ахуйн салбар	Аялал жуулчлалын салбар	Аж үйлдвэрийн салбар	Эрдэс баялгийн салбар	Дэд бүтцийн салбар	Бизнесийн таатай орчин
2016	1	1	0	0	38	0
2017	0	2	0	0	63	1
2018	2	3	1	0	24	1
2019	3	4	1	0	77	0
2020	4	3	1	0	106	0
Дүн	10	13	3	0	308	2

“Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлэгт багтах 336 ТАХ-ны 91.7 хувь нь дэд бүтцийн салбарт, 3.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 3.9 хувь нь аялал жуулчлалын салбарт, 0.9 хувь нь аж үйлдвэрийн салбарт тус тус чиглэсэн байна. Харин эрдэс баялгийн салбарт чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

1.1.2 “Нийгмийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 108 ТАХ-ний 49.1 хувь нь “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгыг хангахад чиглэсэн байна.

Орхон аймагт 2016-2020 оны хооронд хэрэгжсэн 642 ТАХ-ээс “МУТХҮБ- 2030”-ын “Нийгмийн тогтвортой хөгжил” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн 108 ТАХ хэрэгжсэн байна.

“Нийгмийн тогтвортой хөгжил” бүлгийн 3 зорилготой ТАХ-үүд хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал	Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо	Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн
2016	1	5	6
2017	2	9	13
2018	4	5	12
2019	5	5	9
2020	4	15	13

Дүн	16	39	53
-----	----	----	----

“Нийгмийн тогтвортой хөгжил” бүлэгт багтах 108 ТАХ-ны 49.1 хувь нь “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгыг, 36.1 хувь нь “Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо” зорилгыг, 14.8 хувь нь “Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал” зорилгыг хангахад чиглэсэн байна.


1.1.3 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 10.4 хувь нь “Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн байна.

Орхон аймагт 2016-2019 оны хооронд хэрэгжсэн 443 ТАХ-ээс “МУТХҮБ-2030”-ын “Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн 50 ТАХ хэрэгжсэн байна.

“Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлгийн 3 зорилготой ТАХ-үүд хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Усны нөөцийн нэгдсэн менежмент	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	Экосистемийн тэнцвэрт байдал
2016	9	2	4
2017	0	1	11
2018	5	4	1
2019	6	6	1
2020	13	3	1
Дүн	33	16	18

“Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлэгт багтах 67 ТАХ-ны 49.3 хувь нь усны нөөцийн менежмент, 26.9 хувь нь Экосистемийн тэнцвэрт байдал чиглэсэн байна.



“Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлгийн зорилтуудыг хангахад чиглэсэн ТАХ-ний нийт хэрэгжүүлсэн ТАХ-нд эзлэх хувь 2016 онд 17.6%, 2017 онд 10.2%, 2018 онд 12.5%, 2019 онд 8.1%, 2020 онд 8.5% байна.

1.1.4 Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 13.2 хувь нь “Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгыг хангахад чиглэсэн байна.

Орхон аймагт 2016-2020 оны хооронд хэрэгжсэн 642 ТАХ-ээс “МУТХҮБ-2030”-ын “Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн 85 ТАХ хэрэгжсэн байна.



“Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгуудыг хангахад 2016 онд 5 ТАХ, 2020 онд 32 ТАХ хэрэгжсэн байна.

“МУТХҮБ-2030”-ын “Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилтуудыг хангахад чиглэсэн ТАХ-үүдийн нийт хэрэгжүүлсэн ТАХ-нд эзлэх хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Он	Нийт ТАХ-ны тоо	“Тогтвортой хөгжлийн засаглал”	Нийт ТАХ-нд эзлэх хувь
1	2016	85	5	5.9%
2	2017	118	13	11.0%
3	2018	80	9	11.3%
4	2019	160	26	16.3%
5	2020	199	32	16.1%
Дүн		642	85	13.2%

“Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгуудыг хангахад чиглэсэн ТАХ-үүд жил ирэх тусам өссөн байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 96.6 хувь нь “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан.

Тухайн бодлогын баримт бичиг нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, сайн засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүсчилсэн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 зорилго, 47 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2021 оны хооронд нийт 16,174.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ОНХО-аар 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилготой нийцсэн байдлыг графикаар харуулбал:



Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 49.6 хувь нь “Хүний хөгжил” зорилгыг, 4.9 хувь нь “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгыг, 8.3 хувь нь “Эдийн засаг” зорилгыг, 14.9 хувь нь “Сайн засаглал” зорилгыг, 3.3 хувь нь “Ногоон хөнжил засаглал” зорилгыг, 10.7 хувь нь “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгыг, 2.5 хувь нь “Бүсчилсэн хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 5.8 хувь, 7 ТАХ нь “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилгын аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

1.2.1 “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгуудад хамаарах 18 зорилтоос 12 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймагт 2021 онд хэрэгжсэн 121 ТАХ-ээс “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 60 ТАХ, “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгыг хангахад чиглэсэн 6 ТАХ, “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгыг хангахад чиглэсэн 13 ТАХ хэрэгжсэн байна.

“Хүний хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 60 ТАХ 7 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Боловсрол	Эрүүл мэнд	Гэр бүл	Шинжлэх ухаан, инноваци	Хүнд ээлтэй амьдрах орчин	Хөдөлмөрийн зах зээл	Удмын сан
2021	19	14	0	0	27	0	0

Гэр бүл, хөдөлмөрийн зах зээл, удмын сан руу чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна. Харин хүнд ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

“Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгыг хангахад чиглэсэн 6 ТАХ 6 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	Орлогд нийцсэн орон байр	Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	Газрын харилцаа
2021	4	2	0	0	0	0

“Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл” зорилтод чиглэсэн 4 ТАХ, “Орлогд нийцсэн орон байр” зорилтод чиглэсэн 2 ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Харин “Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес”, “Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт”, “Газрын харилцаа” зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

“Амар тайван аюулгүй нийгэм” зорилгыг хангахад чиглэсэн 13 ТАХ 5 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Зэвсэгт хүчин	Дархан хил	Хүн нийгмийн амар тайван байдал	Хууль сахиулах салбарын хөгжил	Мэдээллийн аюулгүй байдал
2021	0	0	13	0	0

“Хүн нийгмийн амар тайван байдал” зорилтод чиглэсэн 13 ТАХ хэрэгжүүлсэн байна. Бусад 4 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

1.2.2 “Эдийн засаг”, “Ногоон хөгжил”, “Бүсчилсэн хөгжил” зорилгуудад хамаарах 13 зорилтын 8 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймагт 2021 онд хэрэгжсэн 121 ТАХ-ээс “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Эдийн засаг” зорилгыг хангахад чиглэсэн 10 ТАХ, “Ногоон хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 4 ТАХ, “Бүс, орон нутгийн хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 3 ТАХ хэрэгжсэн байна.

“Эдийн засаг” зорилгыг хангахад чиглэсэн 10 ТАХ 6 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Чинээлэг Монгол	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд	Ухаалаг санхүүгийн зах зээл	Бүс нутгийн хамтын ажиллагаа	Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн
2021	0	10	0	0	0	0

“Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд” зорилтод чиглэсэн 10 ТАХ-ээс өөр бусад 5 зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

“Ногоон хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 4 ТАХ 4 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Эх байгаль ба анхдагч экосистем	Байгалийн баялгийн үр өгөөж	Үнэт баялаг ус	Хүлэмжийн хийн ялгарал багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил
2021	0	1	1	2

“Байгалийн баялгийн үр өгөөж” зорилтод чиглэсэн 1 ТАХ, “Үнэт баялаг ус” зорилтод чиглэсэн 1 ТАХ, “Хүлэмжийн хийн ялгарал багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил” зорилтод чиглэсэн 2 ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Харин “Эх байгаль ба анхдагч экосистем” зорилтод чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

“Бүс, орон нутгийн хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 3 ТАХ зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Дэд бүтэц	Аялал жуулчлал	Тогтвортой хөдөө аж ахуй
2021	0	0	3

“Тогтвортой хөдөө аж ахуй” зорилтод чиглэсэн 3 ТАХ-ээс бусад зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

1.2.3 “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийн зорилгод чиглэсэн ТАХ-хэрэгжүүлээгүй, “Сайн засаглал”-ын зорилгуудад хамаарах 6 зорилтын 2 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймагт 2021 онд хэрэгжсэн 121 ТАХ-ээс “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Сайн засаглал” зорилгыг хангахад чиглэсэн 18 ТАХ хэрэгжсэн байна. Харин “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

“Сайн засаглал” зорилгыг хангахад чиглэсэн 18 ТАХ 6 зорилттойгоо хэрхэн нийцсэнийг хүснэгтээр харуулбал:

Он	Ухаалаг засаглал	Ухаалаг бүтэц	Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)	Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	Хүний эрхийг дээдэлсэн нийгэм	Авлигагүй засаглал
2021	1	1	3	13	0	0

“Ухаалаг засаглал” зорилтод чиглэсэн 1 ТАХ, Ухаалаг бүтэц зорилтод чиглэсэн 1 ТАХ, “Цахим Монгол” зорилтод чиглэсэн 3 ТАХ, “Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба” зорилтод чиглэсэн 13 ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Харин “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм”, “Авлигагүй засаглал” зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.


1.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөөгүй ч дунд хугацааны бодлоготой нийцүүлж төлөвлөсөн байна.

1.3.1 2016-2020 онд хэрэгжүүлсэн 642 ТАХ-ны 96.3 хувь нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад, 2021 онд хэрэгжүүлсэн 121 ТАХ-ны 94.2 хувь нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан. Үйл ажиллагааны хөтөлбөр нь 5 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2016-2020 оны хооронд нийт 56,320.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 642 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.


Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой ОНХО-аар 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нийцсэн байдлыг графикаар харуулбал:



Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 34.6 хувь нь “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого” зорилтыг, 25.4 хувь нь “Нийгмийн бодлого” зорилтыг, 12.5 хувь нь “Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого” зорилтыг, 23.8 хувь нь “Засаглалын бодлого” зорилтыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 3.7 хувь, 24 ТАХ нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого” зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 24 дугаар тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан. Үйл ажиллагааны хөтөлбөр нь 6 зорилтод хуваагдаж байна. Орхон аймаг 2021 онд нийт 16,174.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой ОНХО-аар 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нийцсэн байдлыг графикаар харуулбал:




Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 34.6 хувь нь “Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого” зорилтыг, 26.5 хувь нь “Хүний хөгжлийн бодлого” зорилтыг, 42.9 хувь нь “Эдийн засгийн бодлого” зорилтыг, 22.3 хувь нь “Засаглалын бодлого” зорилтыг, 2.5 хувь нь “Засаглалын бодлого” зорилтыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 5.8 хувь, 7 ТАХ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого болон “Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого” зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

1.3.2 2016-2021 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүдийг орон нутгийн хөгжлийн индекс тэй нийцүүлэн төлөвлөөгүй хэдий ч хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 88.5 хувь нь ОНХИ-тэй нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Орон нутгийг жигд хөгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан оновчтой төлөвлөхөд ашиглах хөгжлийн индекс тооцох аргачлалыг, Засгийн газрын 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 242 дугаар тогтоолоор “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай”-ыг баталсан байна. Дээрх аргачлалуудыг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Аргачлал шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хүчингүй болгосон байна.

Үндэсний хөгжлийн газраас 2012 онд гаргасан орон нутгийн хөгжлийн индексийг графикаар харуулбал:


Хөгжлийн индекс



Орхон аймгийн дундаж индекс 330 сумын дундаж индексээс боловсрол, эдийн засаг, дэд бүтэц, бусад индекс өндөр байна. Харин эрүүл мэнд, байгаль орчны дундаж индекс доогуур байна.

Засгийн газрын 2018 онд баталсан “Аргачлал шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоолын 4-д “Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.” гэж заасан байтал 2016-2021 оны хооронд ОНХО-аар хэрэгжсэн 775 ТАХ-үүдийг орон нутгийн хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөсөн талаар ямар нэгэн баримт байхгүй байна.

2016-2017 оны хооронд хэрэгжсэн 775 ТАХ орон нутгийн хөгжлийн индекстэй хэрхэн нийцсэн талаарх харьцуулсан судалгааг графикаар харуулбал:




Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 45.03 хувь нь дэд бүтэц, 9.29 хувь нь боловсрол, 13.68 хувь нь эрүүл мэнд, 1.68 хувь нь эдийн засаг, 2.71 хувь байгаль орчин, 12.77 хувь нь засаглалын индекстэй нийцсэн байна.

1.3.3 Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Аялал жуулчлалын өгөөжтэй-Аз жаргалтай иргэд”, “Аялал жуулчлалын бодлого” зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

Орхон аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан нь 9 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2016-2020 оны хооронд нийт 56,320.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 642 ТАХ-г хэрэгжүүлсэн байна.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой ОНХО-аар 2016-2020 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нийцсэн байдлыг графикаар харуулбал:



Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 16.9 хувь нь “Эрүүл-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 1.0 хувь нь “Нийгмийн дэмжлэгтэй-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 0.3 хувь нь “Ажилтай-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 6.4 хувь нь “Оюунлаг, ёс зүй, соёлтой-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 4.7 хувь нь “Эрүүл хүнс, цэвэр орчинтой-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 40.0 хувь нь “Сайхан хотын-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 4.1 хувь нь “Эдийн засгийн өсөлттэй-Аз жаргалтай иргэд” зорилтыг, 23.1 хувь нь “Чадварлаг засаглалтай-Аз жаргалтай иргэд” зорилтыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 3.4 хувь, 22 ТАХ нь Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. “Аялал жуулчлалын өгөөжтэй-Аз жаргалтай иргэд” зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/02 дугаар тогтоолоор “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан нь 8 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2021 онд нийт 16,174.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой ОНХО-аар 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нийцсэн байдлыг графикаар харуулбал:



Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 12.4 хувь нь “Эрүүл мэнд, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн бодлого” зорилтыг, 4.1 хувь нь “Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого” зорилтыг, 13.2 хувь нь “Боловсрол, соёл шинжлэх ухааны хөгжил” зорилтыг, 6.6 хувь нь “Эрүүл хүнс, цэвэр орчин, ногоон хөгжил” зорилтыг, 34.7 хувь нь “Дэд бүтцийн хөгжил” зорилтыг, 0.8 хувь нь “Үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил” зорилтыг, 22.4 хувь нь “Найдвартай засаглал” зорилтыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 5.8 хувь, 7 ТАХ нь Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын аль нэгт хамаарахгүй ТАХ-г хэрэгжүүлсэн байна. “Аялал жуулчлалын бодлого” зорилтыг хангахад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.

1.3.4 2016-2020 оны хооронд Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөрийн хүрэх түвшинг тодорхой тусгаж төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын хүрэх түвшин, үр дүнг тодорхойлоогүй байна.

Энэ нь “Журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 249 дүгээр тогтоолын 54.1³ дэх хэсэгтэй нийцэхгүй байна. /Энэ тогтоол Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор хүчингүй болсон./

³ “бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна”

УИХ-аас 2020 оны 5 дугаар сард Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбоотойгоор Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт жил бүрийн хүрэх түвшинг тодорхойлсон байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь үр дүн, үр нөлөөтэй хэрэгжсэн үү?

Бүлэг 2

Хөрөнгө оруулалтаар 2016 оноос 2021 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

2.1 Хуулийн шаардлага хангасан ТАХ-г хэрэгжүүлсэн ч хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

2.1.1 Хөрөнгө оруулалтын 99.4 хувь нь иж бүрэн зураг төсөлтэй ТАХ хэрэгжсэн байна.

Аймгийн хөрөнгө оруулалтын 2016-2021 онуудын төлөвлөгөөнд тусгагдсан зураг төсөл хийлгэх 754 төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ баталжээ. Үүнээс 595 төсөл, арга хэмжээ зураг төсөлтэй, 159 төсөл, арга хэмжээний зураг төслийг төсөв баталсны дараа гүйцэтгүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Он	Зураг төсөл хийлгэх ТАХ-ний тоо	Зураг төсөлтэй ТАХ-ний тоо	Зураг төсөлгүй ТАХ-ний тоо	Эзлэх хувь
2016 он	123	117	6	4.9
2017 он	129	114	15	11.6
2018 он	95	54	41	43.2
2019 он	147	92	55	37.4
2020 он	175	168	7	4.0
2021 он	79	44	35	46.7
Нийт	754	595	159	21.1

Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг өмнөх онтой дүйцүүлэн баталснаар дараа онд төсөвт өртгийг нэмэгдүүлэн батлах, төсөвт багтаан гүйцэтгэж иж бүрэн бус зураг төсөл болох нөхцөл үүссэн байна.

Зураг төсөл иж бүрэн хийгдээгүйгээс ашиглалтын явцад эвдэрсэн, үр дүнгүй болсон 2016 онд 2 ТАХ, 2019 онд 3 ТАХ байна. Үүнд:

2016 оны хөрөнгө оруулалт:

- Баянцагаан баг болон орон сууцны 2-р хороололд УДДТ барих ажилд нийт 1007.3 сая төгрөг зарцуулсан боловч зураг төсөлд хамгаалалтын хашаа зурвас тусгагдаагүйгээс хамгаалалтын хашаа хийгдээгүй,
- Их залуу багийн ИШС-ний өргөтгөлийн ажилд нэмэлтээр нүүрс хадгалах, үнс гаргах савыг хийсэн ч нүүрс үнсийг машинаар зөөж тээвэрлэх боломжгүй, өрхийн хэрэгцээнд ашиглахаар жижиг хийсэн нь ашиглалтын шаардлага хангахгүй байна.

2019 оны хөрөнгө оруулалт:

- 20-р сургуулийн хөл бөмбөгийн талбай байгуулах ажлын зураг төсөвт усны хаяалга, налуу хийгдээгүйгээс талбай бүхэлдээ усанд автаж гүйлтийн зам, уртын харайлтын талбайн резин будаг хуурч, хиймэл зүлэг наасан цавуу салсан, цахилгааны шонгийн бэхэлгээ муу хийгдсэнээс шон хөдөлгөөнтэй, унахаар болсон байна.
- Жаргалант сумын сургуулийн гадна спортын иж бүрэн талбай байгуулах ажлын зураг төсөвт усны хаяалга, хашаа хийгдээгүйгээс талбайн резин будаг хуурсан байна.
- Оюуны спортын ордны гадна талбайн тохижилтын ажлын зураг төсвийг улсын төсвийн хөрөнгөөр хийж буй авто замын ажилтай уялдуулж хийгээгүйгээс хөрөнгө оруулалтаар хийгдсэн гадна тохижилтын авто зам, явган зам хуулагдсан байдалтай байна. Мөн тус барилгын зураг төсвийг иж бүрэн хийгээгүйгээс одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.

Дээрх ТАХ нь нийт хөрөнгө оруулалтын 0.6 хувийг эзэлж байгаа бөгөөд 99.4 хувь нь иж бүрэн зураг зөсөлтэй ТАХ-г 2016-2021 онуудад хэрэгжүүлсэн байна.

2.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний барилгын чанарт захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад нийт 202,252.3 сая төгрөгийг төлөвлөж, баталсан төсвийн хүрээнд 168,578.9 сая төгрөгийг зарцуулжээ.


Хөрөнгийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөг/

Хөрөнгө оруулалт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт
Шилжих үлдэгдэл	14,023.0	5,236.3	4,388.4	2,861.9	6,159.4	6,365.4	39,034.5
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	8,017.4	6,873.5	5,349.9	12,274.1	11,147.1	13,472.8	57,134.7
ОНХСан	2,396.5	1,899.2	1,541.9	1,975.1	1,815.5	3,788.8	13,417.0
Төсөл хөтөлбөр	4,631.0	4,787.5	5,633.1	6,936.2	8,464.8	8,881.6	39,334.4
Авто замын сан	629.0	380.0	601.3	775.1	867.5	1,246.6	4,499.5
Байгаль хамгаалах сан	494.2	679.4	714.1	900.5	1,054.6	1,188.9	5,031.7
Аваарын зардал	1,200.3	852.5	814.8	922.1	1,576.8	2,319.6	7,685.9
Зураг төслийн зардал	261.9	495.1	563.2	266.0	303.6	551.4	2,441.2
НИЙТ							168,578.9

Хөрөнгө оруулалтын зарцуулалтыг эзлэх хувиар графикаар харуулбал:

Орон нутгийн төсвийн 2016-2021 оны хөрөнгө оруулалтын зарцуулалт



Санхүүжилтийг гэрээнд тусгасны дагуу баталгаажсан барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож байгаа ч холбогдох дансанд хэрэгжүүлэх хяналтыг хэрэгжүүлээгүйгээс гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг зөрүүтэй олгосон, техник хяналтын зардлыг орон нутгийн холбогдох дансанд төвлөрүүлдэггүй зөрчлүүд өмнөх аудитуудаар илэрсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.5-д “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төсвийн ерөнхийлөн захирагчид Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Санхүү хяналт дотоод аудитын албаар хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт шалгалтыг хийлгэхийг зөвлөж байна.

Харин барилгын чанарт тавих захиалагчийн хяналт болон их засварын зохиогчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ, ХЗА, томоохон барилгын зохиогчийн хяналтыг зураг төсөв гүйцэтгэгч компаниуд хэрэгжүүлжээ.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийг баримталж, барилга угсралтын ажилд үе шатны хяналтыг хэрэгжүүлэн, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгч байгууллагууд хэрэгжүүлж, ил, далд ажлыг актаар баталгаажуулан, барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх үед захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2.2 Төсөл арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнг 2020 оноос тодорхойлж эхэлсэн ч үр дүнг нэгтгэсэн мэдээллийн сан үүсгэж үр нөлөөг үнэлээгүй байна.

2.2.1 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг үүсгэж үр нөлөөг үнэлдэггүй байна.

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх” журмын 3.4-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна” гэж заасны дагуу аймгийн ХОХБТХэлтэс нь хөрөнгө оруулалтын төслүүдийн нэгдсэн мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэгч байна.

Гэтэл орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг аймгийн ХБТХэлтэс үүсгээгүй, хөрөнгө оруулалтын үр нөлөөг үнэлээгүй байна.

Энэ нь тус хэлтэс хөрөнгө оруулалтын төслүүдийн нэгтгэсэн мэдээллийн сан үүсгэх мэргэжилтэн байхгүйгээс шалтгаалжээ.

Иймд Үндэсний хөгжлийн газрын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх” журмын 3.5-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны төрийн болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад Мэдээллийн нэгдсэн сангийн тогтвортой үйл ажиллагааг хариуцсан мэргэжилтэнтэй байна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.


2.2.2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хүрэх түвшин, үр дүнг 2020 оноос тодорхойлж эхэлсэн байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөрийн хүрэх түвшинг тодорхой тусгаж төлөвлөөгүйгээс хөрөнгө оруулалтын хүрэх түвшин, үр дүнг тодорхойлоогүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль 2020 онд хэрэгжиж эхэлснээр Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан ажлын хүрэх түвшин, үр дүнг жил бүр төлөвлөж тодорхойлсон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онд хэрэгжсэн шинээр эхлэх ТАХ-г хөрөнгийн ангиллаар авч үзвэл 775 ТАХ-ний 53 ТАХ буюу 23 хувь нь барилга угсралт, 469 ТАХ буюу 48 хувь нь их засвар, 227 ТАХ буюу 15 хувь нь тоног төхөөрөмж, 6 ТАХ буюу 4 хувийг ТЭЗҮ зураг төсөл, 20 ТАХ буюу 10 хувь нь бусад зардалд төлөвлөж, 67,261.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үүнийг графикаар харуулбал:



Хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад дараах үр дүнтэй ажлууд хийжээ.Үүнд:

1. Шинэ барилга

- 2016,2019,2020 онуудад 3 ӨЭМТ-н байр шинээр барьж ашиглалтад оруулж, 10 багийн 43.2 мянган иргэдэд үйлчилж, эрүүл мэндийн төвийн ажиллах ажлын байрны нөхцөл сайжирч, нийт 15 ажлын байр нэмэгдсэн,
- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогцолбор барилга /2016 он/ -барилга ашиглалтад орсноор 21 аймгийн гайхамшгийг аймгийн иргэд үзэх боломж бүрдсэн, 2022 оны байдлаар Соёл урлагийн газар ашиглан үйл ажиллагаагаа явуулж байна.
- Рашаант, Цагаанчулуут, Уртын гол багуудын дунд 280 хүүхдийн цэцэрлэг барих /2017 он/- одоогийн байдлаар 293 цэцэрлэгийн насны хүүхэд хамрагдаж, 42 ажлын байр бий болсон,
- Жаргалант суманд уурын зуух барих /2019 он/- жаргалант багийн 187 өрх, 6 төсвийн байгууллага, 14 ААН дулаанаар бүрэн хангагдаж, 26 ажлын байр бий болсон,
- Яргуйт багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн уурын зуух барих /2019 он/- 150 хүүхдийн цэцэрлэгийг дулаанаар хангаж 1 ажлын байр бий болсон,

2. Авто зам

- 2016-2021 онуудад 8.6 км авто зам шинэчилсэн,
- Авто замын нөхөөсийг 4.72 км талбайд хийсэн,
- Явган зам-36.9 км замыг шинээр хийсэн,
- Шороон зам-119.62 км гэр хорооллын замыг шинээр хийсэн
- Эрүүл мэндийн зам-1.98 км замыг шинээр хийсэн,

3. ИШС- 2016-2021 онуудад нийт 3697м дулаан, халуун хүйтэн усны шугам, 2622м цэвэр усны шугам, 1667 м бохир усны шугам татаж 2021 оны байдлаар гэр хорооллын 178 өрх шугамд холбогдсон байна.

4. Амралт чөлөөт цагийн талбайг 84 байршилд байгуулсан,

5. **Үерийн суваг**-12.43 км урттай үерийн суваг байгуулсан,
6. **Дээвэр засвар**-Хуучин барилгын 365 блок дээврийг бүрэн засварласан,
7. **Тоног төхөөрөмж**- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийг 90 хувь шинэчилсэн, төрийн байгууллагуудыг e-office цахим сүлжээнд нэвтрүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаа цахимжсан байна.
8. **Гэрэлтүүлэг, камержуулалт**- Мэдээлэл шуурхай удирдлагын төв байгуулж аймгийн замын уулзварыг бүрэн камержуулсан, орон сууцны 41 байранд 14,429 м урт гэрлэн чимэглэл, гэр хорооллын 21 багт гэрэлтүүлгийг бүрэн хийсэн байна.


Орон нутгийн төсвийн 2016-2021 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон ТАХ-ээс 792.7 сая төгрөгийн 6 ТАХ-үүдийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна. Тухайлбал:

- Байцааны /505 тн/ зоорь, 2016 он- 276.9 сая төгрөг,
- Дэнж багт ухаалаг худаг, 2018 он-60.0 сая төгрөг,
- Оюуны спортын ордон, 2018 он-159.2 сая төгрөг,
- Говил багийн Тахилтын худаг, 2018 он-81.6 сая төгрөг
- Эрдэнэ багийн 49-р гудамжны худаг, 2018 он-15.0 сая төгрөг
- Шүүхийн шинжилгээний албаны байр, 2020 он- 200.0 сая төгрөг

2.2.3 Хэнийг ч орхигдуулахгүй байх гэсэн зарчмыг баримтлан хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-г хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан орон нутгийн хөгжлийн индекстэй уялдуулан хэрэгжүүлжээ.

Хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад шинээр хэрэгжсэн нийт 775 ТАХ-г салбараар авч үзвэл дараах байдалтай байна.



Дээрх графикаас харахад дэд бүтцийн салбарт нийт хөрөнгө оруулалтын 45 хувийг зарцуулсан нь орон нутгийн иргэдийн ажиллаж амьдрах таатай орчинг бүрдүүлэх, гэр хорооллын айл өрхийг ИШС-нд холбож утааг бууруулахтай холбоотой байна.

Харин бусад салбарын 14.8 хувь нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн ч хөгжлийн индекстэй уялдаагүй ТАХ-үүд байна.

2.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3.1 Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.

ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хэрэгжүүлэхээр 2016-2018 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөндөө тусгасан ч хяналт шалгалт хийгээгүй, 2019-2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Дотоод хяналт шалгалт хийгээгүй нь холбогдох хэлтсүүд баримт материал ирүүлээгүйгээс шалтгаалжээ.

Мөн аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64.1.2-д “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу хэлэлцэн баталсан төсвийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх байтал хяналт хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 69.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг ТЕЗ-д, аймгийн ИТХ-д Төсвийн тухай хуулийн 64.1 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

2.3.2 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан гэх боловч алдаа зөрчил давтан гаргасаар байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2016-2021 онд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 113.0 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 6,822.2 сая төгрөгийн 28 зөрчил арилгуулах албан шаардлага, 31,762.7 сая төгрөгийн 45 зөвлөмжийг хүргүүлжээ. Үүнийг он оноор харуулбал:

2016-2021 онуудад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/					
2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Төлбөрийн акт -4 – 90.6 сая төгрөг	Төлбөрийн акт - 0	Төлбөрийн акт -1 – 22.4 сая төгрөг	Төлбөрийн акт -0	Төлбөрийн акт -0	Төлбөрийн акт -0
Албан шаардлага -8 – 766.6 сая төгрөг	Албан шаардлага -4 – 1,481.6 сая төгрөг	Албан шаардлага -3 – 1.6 сая төгрөг	Албан шаардлага -7 – 194.4 сая төгрөг	Албан шаардлага -4 – 4,033.8 сая төгрөг	Албан шаардлага -2 – 344.2 сая төгрөг
Зөвлөмж - 17	Зөвлөмж - 6	Зөвлөмж - 6-98.4 сая төгрөг	Зөвлөмж - 5-25.7 сая төгрөг	Зөвлөмж - 5- 1,468.8 сая төгрөг	Зөвлөмж - 6- 30,169.8 сая төгрөг

Зөрчлийн биелэлтийг 2022 оны хагас жилийн байдлаар авч үзвэл 113.0 сая төгрөгийн 5 төлбөрийн акт 100 хувийн биелэлттэй, 6,478.0 сая төгрөгийн 26 албан шаардлага биелж, биелэлт 93 хувьтай, 39 зөвлөмж биелж, 87 хувийн биелэлттэй байна.

Аудитаар хүргүүлсэн зөрчлийг тухай бүр арилгасан гэх боловч жил бүр төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх гэсэн зөвлөмж, албан шаардлага, 2019 оноос хойш захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг орон нутгийн холбогдох дансанд төвлөрүүлдэггүй зөрчлүүд давтагдаж байгаа нь зөвлөмж, албан шаардлагын дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээний хяналт сул байгааг илтгэж байна.

Иймд аудитаас хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, цаашид илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар холбогдох хэлтэс албуудад үүрэг өгч, түүний биелэлтийг тооцож байхыг зөвлөж байна.

Мөн төсөв батлахдаа Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд тусгах зардал бууруулах саналыг хэлэлцэж төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г баталж байх шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 92.8 хувь нь “МУТХҮБ-2030” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.
- “Эдийн засгийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 336 ТАХ-ний 91.7 хувь нь дэд бүтцийн салбар руу чиглэсэн байна.
- “Нийгмийн тогтвортой хөгжил” бүлэгт хамаарах 108 ТАХ-ний 49.1 хувь нь “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгыг хангахад чиглэсэн байна.
- Нийт хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 13.2 хувь нь “Тогтвортой хөгжлийн засаглал” бүлгийн зорилгыг хангахад чиглэсэн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн 94.2 хувь нь “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.
- “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгуудад хамаарах 18 зорилтоос 12 зорилтыг чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.
- “Эдийн засаг”, “Ногоон хөгжил”, “Бүсчилсэн хөгжил” зорилгуудад хамаарах 13 зорилтын 8 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ хэрэгжүүлээгүй байна.
- “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийн зорилгод чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй, “Сайн засаглал”-ын зорилгуудад хамаарах 6 зорилтын 2 зорилтыг хангахад чиглэсэн ТАХ хэрэгжүүлээгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөөгүй ч дунд хугацааны бодлоготой нийцүүлж төлөвлөсөн байна.
- 2016-2020 онд хэрэгжүүлсэн 642 ТАХ-ны 96.3 хувь нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад, 2021 онд хэрэгжүүлсэн 121 ТАХ-ны 94.2 хувь нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн байна.
- 2016-2021 оны хооронд хэрэгжүүлсэн ТАХ-үүдийг орон нутгийн хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөөгүй хэдий ч, хэрэгжүүлсэн ТАХ-үүдийн 88.5 хувь нь ОНХИ-тэй нийцсэн байна.
- Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Аялал жуулчлалын өгөөжтэй-Аз жаргалтай иргэд”, “Аялал жуулчлалын бодлого” зорилтуудад чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлээгүй байна.
- 2016-2020 оны хооронд Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байгаа хэдий ч хуульд нийцээгүй, зураг төсөлгүй төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар төлөвлөж баталсаар байна.
- Хөрөнгө оруулалтын 99.4 хувь нь иж бүрэн зураг төсөлтэй ТАХ хэрэгжсэн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний барилгын чанарт захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ч хөрөнгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг үүсгэж үр нөлөөг үнэлдэггүй байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хүрэх түвшин, үр дүнг 2020 оноос тодорхойлж эхэлсэн байна.
- Хэнийг ч орхигдуулахгүй байх гэсэн зарчмыг баримтлан хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд дотоод хяналт, шалгалт хийгээгүй байна.
- Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан гэх боловч алдаа зөрчил давтан гаргасаар байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат-д

- “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засгийн газар, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүй ТАХ-батлахгүй байх.
- Төрийн аудитын байгууллагаас хүргүүлж буй зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г баталж байх.

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, төсөл арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т

- Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд заасан зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн ТАХ-г төлөвлөж байх.
- Хөгжлийн индексийн үр дүнг аймгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байх.
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн санг үүсгэж, хөрөнгө оруулалтын үр нөлөөг үнэлж байх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ**ОРХОН АЙМАГ****ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,

Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: 7035 5590, Факс: (976)7035 2621

Цахим шуудан: info@erdenet.mn

2022.10.18

№

06/2169

танай

-ны №

-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Орхон аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлт, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө /2016-2021/ гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал алга байна. Зөвлөмжийн дагуу үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА С.ДАВААДОРЖ



Б.Бүтэн-Ундрах

Тайлан

Х/18
6122022763